



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/159

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.8, 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Рамын дэнж, Наймаа буланд үерийн далан барих-голын голидрол өөрчлөх ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Э.Дашдулам (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

И.Маралмаа (Газрын даамал)

Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
мэргэжилтэн)


А.Мандахзул (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгч)

Э.Амарсайхан (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчид бүртгэх шаардлагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

827301328

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/